



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 9 сарын 15 өдөр

Дугаар 30

Зуунмод

Г Хүсэлт тавьж, хамтран
ажиллах тухай Г

Аймгийн нутаг дэвсгэрт олгогдсон ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн байдлыг зарим сумдад шалган танилцаж, судалгаа хийсэн тухай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч, Ажлын хэсгийн ахлагч Ц.Дашдэмбэрэлийн мэдээллийг хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ нь:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс томилогдсон Ажлын хэсэг Алтанбулаг, Баян, Баянчандмань, Заамар, Сэргэлэн сумд, аймгийн Газрын харилцаа, хот байгуулалтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газарт ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тухай Мэдэгдэлд санал өгсөн байдал, тусгай зөвшөөрөл олгоход холбогдох хуулиудыг хэрхэн мөрдөж байгаа, тусгай зөвшөөрөл эзэмшигчид үйл ажиллагаагаа хэрхэн явуулж байгааг судлан үзэж зохих дүгнэлт гаргасан байна.

Энэ оны 8 дугаар сарын эхний байдлаар аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын хайгуулын 376.1 мян. га газрыг хамарсан 163 тусгай зөвшөөрөл, ашиглалтын 134,2 мян.га газрыг хамарсан 291 тусгай зөвшөөрөл, нийт 510.3 мян.га газрыг хамарсан 454 тусгай зөвшөөрөл олгогдсон нь нийт нутаг дэвсгэрийн 6.9 хувийг эзлэж байна. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгоход зарим тохиолдолд хууль тогтоомж зөрчигдэж байгаагийн зэрэгцээ тусгай зөвшөөрөл эзэмшигчид ч хууль тогтоомжийг зөрчих явдал олонтаа гарч байна. Тухайлбал, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн “Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг” гэсэн 11 дүгээр зүйлийн 11.1.6-д ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгоход аймгийн Засаг даргын саналыг авахаар заасан байхад Ашигт малтмалын газар 2013-2016 онд 87.3 мян.га газрыг хамарсан 62 тусгай зөвшөөрөл олгоходоо санал аваагүй байна. Мөн Ашигт малтмалын тухай хуулийн “Өргөдлийг бүртгэх, хянан шийдвэрлэх” гэсэн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх заалтын дагуу ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгоход орон нутгийн саналыг авах ёстой байтал 2015-2016 онд 17.9 мян.га газрыг хамарсан 12 тусгай

0100030

зөвшөөрөлийг санал авалгүйгээр шууд, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг даргаас “дэмжих боломжгүй” гэж санал өгсөн байхад 220.4 мян.га газрыг хамарсан 64 тусгай зөвшөөрөл олгосон байна. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан Баян сумын газар нутагт 9 хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсон байна. Мөн Заамар сумын орон нутгийн тусгай хэрэгцээнд авч Кадастрын албандаа бүртгүүлсэн газар Засгийн газрын шийдвэрээр 4, аж ахуйн нэгжийн хүсэлтээр 2 хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсон байна.

Тусгай зөвшөөрөл олгодог төрийн захиргааны байгуулага нь “Ашигт малтмалын тухай” хуулийн 19.10-т заасны дагуу хайгуулын тусгай зөвшөөрөл огосон даруйд, 26.7-д заасны дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосноос хойш 7 өдөрт багтаан тухайн зөвшөөрлөөр олгогдсон талбай байрших аймаг, сумын Засаг даргад мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтлэх үүргээ хэрэгжүүлэхгүй байна. Мөн хуулийн “Байгаль орчныг хамгаалах талаар хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг” гэсэн 38 дугаар зүйлийн 38.1.1-д заасан, тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж хайгуулын тусгай зөвшөөрөл авснаас хойш 30 хоногийн дотор холбогдох сумдын Засаг даргатай зөвшилцэн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулах үүргийг биелүүлэхгүй байна. Түүгээр ч барахгүй тусгай зөвшөөрөл авснаас хойш нэг ба түүнээс дээш жилийн хугацаа өнгөрөөд байхад орон нутагт ирж мэдэгдэхгүй байгаа аж ахуйн нэгжүүд цөөнгүй байна.

Аймгийн нутагт олгогдсон ашигт малтмалын 454 тусгай зөвшөөрлийг 268 аж ахуйн нэгж эзэмшиж байгаагаас 32 аж ахуйн нэгж хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг хоёуланг нь эзэмшиж байна. Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдээс “Алтандорнод Монгол” ХХК ашиглалтын 18, хайгуулын 3 бүгд 21, “Бумбат” ХХК ашиглалтын 7, хайгуулын 4 бүгд 11, 3 аж ахуйн нэгж тус бүр 6, 3 аж ахуйн нэгж тус бүр 5, 4 аж ахуйн нэгж тус бүр 4, 14 аж ахуйн нэгж тус бүр 3, 53 аж ахуйн нэгж тус бүр 2, 189 аж ахуйн нэгж тус бүр 1 тусгай зөвшөөрөл эзэмшиж байна.

Энэ оны байдлаар аймгийн нутаг дэвсгэрт ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 182, хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч 118 аж ахуйн нэгжүүдийн 50 хүрэхгүй хувь нь л үйл ажиллагаа явуулж байна. Аймгийн нутаг дэвсгэрт ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгогдсон 134.2 мян.га талбайн 28.9 мянга буюу 21.5 хувийг нь сумын Засаг даргын захиралж гаргуулан эзэмшиж газрын төлбөр төлж байна.

Энэ тоон үзүүлэлт нь цаашид аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл нэмж олгох нь хэр ач холбогдолтойг нутгийн удирдлагын байгууллага эргэлзэхэд хүргэж байна. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд өөрийн санхүүгийн чадавхи, хөрөнгө оруулалтын байдлаас шалтгаалан үйл

ажиллагаагаа явуулж чадахгүй байж болох талтай ч, тусгай зөвшөөрлөө зарж хялбар аргаар мөнгө олох зорилготой аж ахуйн нэгжүүд цөөнгүй байж болох юм гэсэн хардлагыг зүй ёсоор төрүүлж байна. Иймд аймгийн нутгийн удирдлагын байгууллага холбогдох яам, агентлагатай хамран ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг шалган танилцаж, зохих судалгаа хийж цаашдын төлөвийн талаар нь дүгнэлт гаргах нь зүйтэй гэж үзэв.

Ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл олгож буй байдал, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааны талаар иргэдээс гомдол санал гарч байгаагийн нэг шалтгаан нь анх тусгай зөвшөөрөл олгох боломжтой тухай Мэдэгдэлд санал өгөхөд хуульд заасан хугацаанд баригдаж тухайн тусгай зөвшөөрөлд хамрагдах газар нутгийг харьялдаг багийн удирдлага, тэнд нутагладаг малчид, иргэдэд танилцуулж санал хүснэгтийг нь авч чаддагтуйтэй холбоотой байна. Нөгөө талаар тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулахдаа байгаль орчныг хамгаалах, иргэд-малчдын эрх ашгийг хүндэтгэх талаар учир дутагдалтай ажиллаж байна. Иймд “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-д заасан “эрдэс баялгийн салбарыг хөгжүүлэхэд төрийн байгууллага, аж ахуйн нэгж нээлттэй, ил тод, хариуцлагатай байх” зарчмыг удирдлага болгон тухайн нутаг дэвсгэрт геологи хайгуулын ажил болон уул уурхайн олборлолт эхлүүлэхийн өмнө тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, орон нутгийн удирдлага, иргэдийн хоорондын харилцан ойлголцох нөхцөлийг бүрдүүлэх, уул уурхайн төслийн нийгэм, эдийн засгийн ач холбогдлыг тайлбарлан таниулах ажлыг өргөн хийх шаардлагатай байна. Энэ ажлыг ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох эсэхэд санал өгөхөөс эхлэх нь зүйтэй гэж үзэв.

Аймгийн мал сүргийн тоо жилээс жилд өсөж 4.5 саяд хүрч бэлчээрийн даац хүрэлцэхгүй болж байгаа, хүн амын тоо, үйлдвэрлэл үйлчилгээний хэмжээ цаашид ч нэмэгдэхээр байгаа төлөв байдлыг ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох асуудалтай нягт уяалдаатайгаар авч үзэх шаардлагатай байна.

Баян сумын нутагт “Эрдэнийн Цахирмаа тал” ХХК-д 47.5 кг алтны нөөцтэй 701.2 га, “Каймекс” ХХК-д 20 кг алтны нөөцтэй 1044.9 га газарт ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон нь багахан алтны төлөө ихээхэн байгаль орчныг доройтуулж байгаа нь харагдаж байна.

Уул уурхайн зорилулалтаар газар олгох, газрын төлбөр төлүүлэх зэрэг асуудлыг зохицуулж буй “Газрын тухай”, “Газрын хэвлэлийн тухай”, “Ашигт малтмалын тухай” хуулиудын хоорондын уялдааг хангаж боловсронгуй болгох шаардлагатай байгаа нь амьдарлаас харагдаж байна.

“Ашигт малтмалын тухай”, “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” болон холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангаж, байгалийн баялгийг өнөө ба ирээдүйн эрх ашгийн үүднээс зохистой ашиглах зарчмыг хангаж, геологийн судалгаа, хайгуулын ажлыг хууль, тогтоомж орон нутгийн эрх ашиг, байгалийн өөрийн нь даац чадамжид нийцүүлэн явуулах, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, байгаль орчныг хамгаалах шаардлага, хүрээлэн байгаа орчны экологийн тэнцвэрт байдлыг хангасан ил тод байдлын болон хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх зорилгоор нутгийн удирдлагын байгууллага, уул уурхайн төрийн захиргааны байгууллагын дэмжлэг туслалцааг авч, хууль тогтоомжийн хүрээнд харилцан ойлголцож, хамтран ажиллах явдлыг өргөжүүлэх нь зүйтэй байгааг тэмдэглээд Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.1.2-ын “з”, 19.1, 20.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Ашигт малтмалын тухай” хуулийн 19.4 дэх заалтыг зөрчиж аймгийн Засаг даргын санал авалгүйгээр олгогдсон хайгуулын тусгай зөвшөөрлийг 1 дүгээр хавсралтын ёсоор, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 11.1.6 дахь заалтыг зөрчиж аймгийн Засаг даргын санал авалгүйгээр олгогдсон ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус тогтоож цуцуулах саналыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд уламжилсугай.

2. Ашигт малтмалын тухай хуулийн 38.1.1 дэх заалтыг зөрчиж тусгай зөвшөөрөл авснаас хойш 30 хоногийн дотор холбогдох сумдын Засаг даргатай зөвшилцэж байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний төсөл боловсруулаагүй, мөн хуулийн 33.1 дэх заалтын дагуу жил бүр хайгуулын ажлын зардлын доод хэмжээнээс багагүй зардал гаргаж хайгуул хийсэн эсэх нь орон нутгагт тодорхойгүй байгаа аж ахуйн нэгжүүдийн тусгай зөвшөөрлүүдийг 3 дугаар хавсралтын ёсоор, сумдын Засаг даргын захирамж гаргуулан олборлот явуулж байгаад үйл ажиллагаагаа зогсоож орон нутагтай харьцаж газрын төлбөр төлөхгүй, нөхөн сэргээлт хийхгүй байгаа аж ахуйн нэгжүүдийн тусгай зөвшөөрлүүдийг 4 дүгээр хавсралтын ёсоор тус тус тогтоож, орон нутагтай хамтран судлан үзэж шаардлагатай арга хэмжээ авах саналыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн болон Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд уламжилсугай.

3. “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Ашигт малтмалын тухай”, “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг аймаг, холбогдох сумдтай хамтарсан нэгдсэн ажлын хэсэг томилж шалган

танилцах саналыг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт тус тус уламжилсугай.

4. “Газрын хэвлийн тухай хууль”-ийн 4-р зүйлийн 1, 8-р зүйлийн 2-ын 2, 11-р зүйлийн 1, “Газрын тухай хууль”-ийн 33.1.2, 55.1 дэх заалтууд болон “Газрын төлбөрийн тухай” хуулийг “Ашигт малтмалын тухай хууль”-ийн холбогдох заалтуудтай буюу өөр тухай” хуулийг “Ашигт малтмалын тухай хууль”-ийн холбогдох заалтуудтай буюу өөрчлөлт оруулах, эсвэл тайлбар хооронд нь нягт уялдуулан боловсрогуй болгон өөрчлөлт оруулах, гаргуулах асуудлыг судлан үзэж шийдвэрлүүлж өгөх саналыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн, Барилга, хот байгуулалтын, Байгаль орчин, аялал жуулчлалын яамдад тавих нь зүйтэй гэж үзсүгэй.

5. Зохих тооцооны үндсэн дээр 50 кг-аас бага нөөцтэй газарт ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохгүй байх асуудлыг судлан шийдвэрлүүлэх саналыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн, Байгаль орчин, аялал жуулчлалын яамдад уламжилсугай.

6. “Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай” хууль батлагдахаас өмнө олгогдсон барилгын материал олборлох ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах, шилжүүлэх, цуцлах асуудлыг Ашигт малтмалын газар, аймаг хоёрын хэн нь хариуцахыг даруй шийдвэрлэх саналыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд, эдгээр тусгай зөвшөөрөлтэй холбогдох материалыг аймагт ирүүлэх хүсэлтийг ашигт малтмалын газарт тус тус уламжилсугай.

7. Энэ тогтоолын тэмдэглэлд дурдагдсан шалтгаан нөхцөлүүдийг тодотгох, 2 дугаар заалтын хэрэгжилтийг хангах хүртлэх хугацаанд тус аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл хүлээн авахгүй байх, ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохгүй байх зохион байгуулалтын арга хэмжээ авах хүсэлтийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд уламжилсугай.

8. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /Д.Батбаяр/-д үүрэг болгосугай.



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2016 оны эхарын ... ны өдрийн
Зоотогтоолын Нэгдүгээр хэвсралт

Ашигт малтмалын тухай хуулийн 19.4 дэх заалтыг зөрчин аймгийн Засаг даргын
санал авалгүйгээр олгогдсон хайгуулын тусгай зөвшөөрлийн жагсаалт

Д/д	Сум, дүүрэг	Аж ахуйн нэр	Тусгай зөвшөөрлийн дугаар	Талбайн хэмжээ /га/	Олгосон он сар өдөр
1	Баян	Нутгийн-орд	17982	519.26	2015.02.27
2	Эрдэнэ	Хурын шүүдэр ХХК	11000029	27.16	2015.04.14
3	Заамар	Уянган	16224	134.67	2015.12.15
4	Орхонтуул, Заамар	Даблью Ти Эл Ди	20072	0.01	2016.01.15
5	Алтанбулаг	Могул майнинг партнерс	19909	6,402.71	2016.02.03
6	Орхонтуул, Заамар	Арвингазар	20200	0.01	2016.02.03
7	Алтанбулаг	Пибоди	19484	4,959.29	2016.04.04
8	Заамар	Монголосцветмет	20520	554.61	2016.05.02
9	Заамар	Монголосцветмет	20521	1,885.17	2016.05.02
10	Заамар	Монголосцветмет	20523	144.83	2016.05.02
11	Заамар	Монголосцветмет	20580	2,585.65	2016.06.20
12	Баяндэлгэр	Занарт-Уул	20583	671.43	2016.06.24

Нийт : 17,884.80 га

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2016 оны 09.сарын 15..ны өдрийн 10:00
тогтоолын Хөөрдугаар хавсралт

“Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай “хуулийн 15.10.6 дахь заалтыг зөрчиж аймгийн Засаг даргын санал
авалгүйгээр олгогдсон ашиглалтын тусгай зөвшөөрлийн жагсаалт

Д/д	Жагсаалт	ТЗ-ийн дугаар	Талбайн нэр	Талбайн хэмжээ (га)	Сум / дүүрэг	Эзэмшигч	Олгосон огноо
1	MV-016978	16978	Цоцгоны мухар	411.31	Заамар	Эм Жи Эл ресурс	2012.01.05
2	MV-016990	16990	Шанаган	887.13	Баянжаргалан	Жи Эл Ди Ви	2012.01.12
3	MV-017018	17018	Их булаг	622.30	Баян	Ти Жи Вай	2012.04.06
4	MV-017029	17029	Ар богол	41.66	Архуст	Аллагтайцэцэн	2012.05.18
5	MV-017369	17369	Налгар	60.38	Алтанбулаг	Платинумланд	2012.05.22
6	MV-017209	17209	Налгар	91.78	Алтанбулаг	Эм-Капитал	2012.05.22
7	MV-017210	17210	Налгар	58.63	Алтанбулаг	Ти Эн энд Юу	2012.05.22
8	MV-017107	17107	Налгар	86.69	Алтанбулаг	Нэйшнл инженеринг групп	2012.05.22
9	MV-017032	17032	Налгар	145.85	Алтанбулаг	Ти Эн энд Юу	2012.05.22
10	MV-017286	17286	Налгар	92.81	Алтанбулаг	Стар ложестик ресурс	2012.05.22
11	MV-017063	17063	Шанд худаг-2-1	22.11	Баян	Тэвхэн	2012.06.08
12	MV-017099	17099	Жаргалант	80.73	Баянжаргалан	Жи Эл Ди Ви	2012.08.10
13	MV-017171	17171	Хараат	25.11	Алтанбулаг	Алтансүлжээ системос	2012.10.12
14	MV-017173	17173	Төгрөг	235.52	Баян, Баянжаргалан	Төгрөгтэл	2012.10.15
15	MV-017188	17188	Цайдам	79.16	Баян	Цэцэнс холдинг	2012.10.17
16	MV-017187	17187	Цайдам-1	256.20	Баян	Цэцэнс майнинг энд энержи	2012.10.17
17	MV-020388	20388	Цайдам-1	650.94	Баян	Цэцэнс холдинг	2012.10.17

18	MV-020335	20335	Цайдам-1	1,404.07	Баян, Баянжаргалан	Цэцэнс холдинг	2012.10.17
19	MV-017198	17198	Бумбат-5	71.12	Заамар	Бумбат	2012.11.02
20	MV-017224	17224	Сонин хангай-1	350.56	Баянцогт	Сонинхад	2012.12.04
21	MV-017232	17232	Улаан-Үүд	607.94	Баян-Өнжүүл	Умардбаян	2012.12.13
22	MV-017257	17257	Гозгор уул	341.48	Сэргэлэн	ЗТХ	2013.02.04
23	MV-017259	17259	Цагаан чулуут уул	25.34	Баян	Баян метал	2013.02.15
24	MV-020502	20502	Цагаан чулуут уул	424.73	Баян	Баян металл майнинг	2013.02.15
25	MV-020573	20573	Цагаан чулуут уул	641.28	Баян	Рео майнинг	2013.02.15
26	MV-017304	17304	Баянголын дэнж-1	158.16	Заамар	Тод-Ундрага	2013.04.18
27	MV-017310	17310	Дунд бөхөг	25.21	Алтанбулаг	Шижирхайрга	2013.04.30
28	MV-017349	17349	Нүүрст	2,497.04	Архуст, Баян, Баянжаргалан	Модунресурсэс	2013.07.09
29	MV-017363	17363	Айргийн энгэр	147.74	Баян	Болдцэн	2013.08.13
30	MV-017375	17375	Цайдам	1,334.50	Баян	Монкоул петро майнинг	2013.08.29
31	MV-017376	17376	Цайдам хөндий	831.62	Баян	Монкоул петро майнинг	2013.08.29
32	MV-017377	17377	Зүүн цайдам	1,174.81	Баян	Монкоул петро майнинг	2013.08.29
33	MV-017388	17388	Салхит	319.72	Алтанбулаг	Си Би Жи Эм	2013.09.27
34	MV-017404	17404	Бөхөгийн хөндий	59.89	Алтанбулаг	Ээмдэ	2013.10.17
35	MV-017411	17411	Бөхөгийн хөндий-3	114.36	Алтанбулаг	Гангар-Инвест	2013.10.31
36	MV-017412	17412	Дунд бөхөг	35.09	Алтанбулаг	Урал дизел	2013.10.31
37	MV-017423	17423	Замын худаг	251.53	Баян	Түмэнтэл	2013.11.27
38	MV-017426	17426	Ногоон уул	32.39	Баяндэлгэр	Монгол вазальт	2013.12.02
39	MV-017470	17470	Шанаган-2	486.77	Баян, Баянжаргалан	Пибодивинсвэй ресорсез	2014.02.06
40	MV-017479	17479	Гал баян	352.97	Баян,	Софт коал	2014.02.28

					Баянжаргалан		
41	MV-017496	17496	Бор үзүүр	570.92	Баян	Давхарсолонго	2014.03.31
42	MV-017499	17499	Бор толгой	376.18	Заамар	Ньюхаппи	2014.04.02
43	MV-017512	17512	Их булаг	388.62	Баян	Эрдэнийн цахирмаа тал	2014.04.16
44	MV-017514	17514	Баян	118.50	Сэргэлэн	Төв эрдэнэ сант	2014.04.17
45	MV-017515	17515	Хөмөөлт-1	9,136.28	Баянжаргалан	Коммонмакс	2014.04.18
46	MV-017516	17516	Төгрөг	23,645.40	Баян, Баянжаргалан	Коммонмакс	2014.04.18
47	MV-017536	17536	Цайдам-1	7,489.68	Баянжаргалан	Бөөрөлжүүтийн тал	2014.05.14
48	MV-017555	17555	Шанд худаг	35.49	Баян	Шохой цагаан булаг	2014.06.17
49	MV-017566	17566	Шанд худаг-2	11.05	Баян	Тэвхэн	2014.07.03
50	MV-017567	17567	Шанд худаг	95.49	Баян	Баянхурай	2014.07.03
51	MV-017575	17575	Хөмөөлт-2	6,129.84	Баянжаргалан	Коммонмакс	2014.07.10
52	MV-017604	17604	Харганы ам-1	42.12	Борнуур	Туншан шиандон	2014.09.05
53	MV-017606	17606	Дэндэр овоо	97.20	Баян	СТБЛ	2014.09.09
54	MV-017642	17642	Баянголын дэнж-1	143.55	Заамар	Тод-Ундрага	2014.10.22
55	MV-017643	17643	Баянголын дэнж-1	78.33	Заамар	Тод-Ундрага	2014.10.22
56	MV-017644	17644	Баянголын дэнж-1	26.29	Заамар	Тод-Ундрага	2014.10.22
57	MV-017684	17684	Сааль толгой	65.11	Баян, Багахангай	Этранс	2014.12.12
58	MV-017743	17743	Шанд худаг	36.42	Баян	Ариг гол	2015.01.15
59	MV-018116	18116	Цайдам	3,071.14	Баян	Тэнгрипетро чэмикалс	2015.03.11
60	MV-018117	18117	Цайдам-6, 20, 21	1,910.07	Баян	Тэнгрипетро чэмикалс	2015.03.11
61	MV-018434	18434	Шанаган	1,015.18	Баянжаргалан	Штайнколе	2015.04.07
62	MV-018498	18498	Ховилийн хоолой	791.85	Баян, Баянжаргалан	Петрокоал	2015.04.10
63	MV-018899	18899	Баян	260.66	Баян	Нутгийн-орд	2015.06.10
64	MV-018925	18925	Зараагийн тал	2,354.82	Баян-Өнжүүл	Эрдэнэжас	2015.06.16

65	MV-018933	18933	Бага Өнжүүл	510.36	Баян-Өнжүүл	Цогт-Онон	2015.06.18
66	MV-018995	18995	Баян голын эх	189.11	Заамар	ЭКО АЛТ	2015.07.07
67	MV-019328	19328	Зүлэгт	1,967.96	Баян	Түшээговь	2015.09.18
68	MV-019638	19638	Бумбат-6	515.06	Заамар	Гурвантамга	2015.10.20
69	MV-019940	19940	Харуул овоо-5	1,983.01	Алтанбулаг, Баян-Өнжүүл	Эрдэнэжас	2015.11.05
70	MV-019938	19938	Бумбат-2	690.40	Заамар	Илтгоулд	2015.11.06
71	MV-020387	20387	Хант	12.60	Алтанбулаг	Монголын алт МАК	2015.12.14
72	MV-020426	20426	Баян-Овоот уул	66.45	Заамар	Арголд	2016.01.04
73	MV-020458	20458	Их салаа	1,840.53	Бүрэн	Эрдэнэжас	2016.02.04
74	MV-020483	20483	Бумбат-3	612.67	Заамар	Заамар гоулд	2016.03.04
75	MV-020484	20484	Бумбат-1	630.01	Заамар	Илтгоулд	2016.03.04
76	MV-020492	20492	Өндөр	701.15	Баян	Эрдэнийн цахирмаа тал	2016.03.25
77	MV-020496	20496	Үнэгтийн овоо	1,445.30	Дэлгэрхаан	Миллениумсторм	2016.03.31
78	MV-020501	20501	Зүүн цагаан хошуу	529.38	Баянжаргалан	Цанзирунли	2016.04.07
79	MV-020579	20579	Бор толгой	208.83	Заамар	Говьметалл	2016.06.16
80	MV-020598	20598	Сонин хангай-1	2,954.41	Баянцогт	Сонинхад	2016.07.20
81	MV-020602	20602	Доргонот, Улаан ухаа	3,506.94	Заамар	Ай Би Би Ай	2016.07.25
82	MV-020603	20603	Баянтал	1,044.89	Баян	Каймекс	2016.07.27
83	MV-020607	20607	Чулуут	700.90	Баян	Такаражин	2016.07.29

Нийт талбай: 93.536.78 га

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчийн
2016 оны 09-р сарын 15-ны өдрийн
жогоруулалтад тогтоолын Гуравдугаар хавсралт

**Ашигт малтмалын тухай хуулийн 33.1, 38.1.1 дахь заалтуудыг хэрэгжүүлэхгүй байгаа
хайгуулын тусгай зөвшөөрлийн жагсаалт**

Д/Д	Жагсаалт	ТЗ-ийн дугаар	Талбайн нэр	Талбайн хэмжээ (га)	Сум / дүүрэг	Эзэмшигч	Олгосон огноо
1	XV-003828	3828	Доргонот, Улаан ухаа	220.95	Дашинчилэн, Заамар	Алтандорнод монгол	2001.11.1
2	XV-006325	6325	Хавцгайн дэл	6,262.92	Баян, Баянжаргалан	Адамасмайнинг	2003.09.17
3	XV-007151	7151	Цагаан ондөр	1,487.78	Баян	Баярконстракшн	2004.03.26
4	XV-007941	7941	Төгрөг нүүр-1	5,165.66	Баян, Баянжаргалан	Адамасмаунтин	2004.07.16
5	XV-008501	8501	Хараатын овоо	6,708.61	Баян	Цантын жим	2004.10.04
6	XV-009177	9177	Илгэн булаг	78.52	Баян	Эхлэл-Ургац	2005.01.21
7	XV-009688	9688	Энгэр ар	1,647.48	Баян	Лукрий	2005.05.02
8	XV-010407	10407	Авдрант	1,960.33	Баяндэлгэр, Эрдэнэ	Принципал инвестмент	2005.09.06
9	XV-011075	11075	Хиатай	2,109.01	Мөнгөнмөрь	Эм Си Икс Жи	2006.01.06
10	XV-011101	11101	Цагаан овоо	51.78	Сэргэлэн	Эрдэнэ Мандал	2006.01.12
11	XV-012646	12646	Майхант	2,578.73	Баянцогт, Баянчандмань	Бидвикэн	2007.08.20
12	XV-013702	13702	Гурван овоо	2,600.43	Дэлгэрх�ан	Ди Эс Эн Кэй	2008.05.15
13	XV-013801	13801	Дэндгэр овоо	649.98	Баян	СТБЛ	2008.06.12
14	XV-014256	14256	Баян	492.25	Баян	Шинэ мандал өргөө	2008.10.08
15	XV-017312	17312	Баян	318.83	Баян	Шинэ мандал өргөө	2008.10.08
16	XV-014340	14340	Баян өнжүүл	2,771.78	Баян-Өнжүүл	Геосигналс	2008.10.22
17	XV-011075	11075	Хиатай	2,109.01	Мөнгөнмөрь	Эм Си Икс Жи	2006.01.06
18	XV-013826	13826	Харгана	109.23	Борнуур	Гунбилэг гоулд	2008.06.20
19	XV-013947	13947	Харганы ам	221.51	Борнуур	Итгэлтхүүлэг	2008.07.31
20	XV-014071	14071	Жоншт	494.15	Баяндэлгэр	Би Эс Ти Эс	2008.08.29
21	XV-014140	14140	Гашууны тал	0.04	Баян, Багахангай	ЦЕТ	2008.09.09
22	XV-013167	13167	Сэргэн уул	714.58	Цээл	Голденсаве	2008.01.14
23	XV-013629	13629	Лүн ихэр уул	2,126.73	Цээл	EOS	2008.04.30

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2016 оны Өвсарын 14. ны өдрийн
тогтоолын Дөрөвдүгээр хавсралт

Газрын төлбөр төлөхгүй, үйл ажиллагаа явуулахгүй, нөхөн сэргээлт хийхгүй байгаа тусгай зөвшөөрлийн жагсаалт

	Жагсаалт	ТЗ-ийн дугаар	Талбайн нэр	Талбай н хэмжээ (га)	Сумдүүрэг	Эзэмшигч	Эзэмшигч регистр	Олгосон огноо
01	MV-001137	1137	Урд дэлэнгийн дэнж	114.11	Заамар	Буд-Инвест	2100754	1995.12.18
2	MV-000290	290	Баянголын гольдрол	426.09	Бүрэгхангай, Заамар	Баянгол эко заамар	5906865	1996.07.22
3	MV-000360	360	Баян-Эрхэт	104.91	Баянжаргалан	Эрэл	2027194	1996.07.22
4	MV-017160	17160	Бумбат	24.46	Заамар	Бумбат	2075652	1997.11.14
5	MV-017147	17147	Баг хайлаастын амны эх	166.08	Заамар	Бумбат	2075652	1999.07.30
6	MV-003066	3066	Нүүрст хонхор	81.84	Баянжаргалан	Пибодивинсвэй ресорсез	5170672	2001.03.19
7	MV-007863	7863	Нүүрст хонхор-1	202.46	Баянжаргалан	Пибодивинсвэй ресорсез	5170672	2001.03.19
8	MV-004121	4121	Цагаан эрэг	33.53	Заамар	Их тохойрол	2784262	2002.02.01
9	MV-004404	4404	Цагаан тал, Дагналтай	275.98	Мөнгөнморьт	Скарн	2841002	2002.05.14
10	MV-004773	4773	Галт	35.89	Заамар	Антракит	2711818	2002.08.21
11	MV-005485	5485	Авдрант	30.06	Лүн	Авдрант хайрхан	2683857	2003.03.10
12	MV-017158	17158	Бумбат 115	24.43	Заамар	Бумбат	2075652	2003.11.11

13	MV-017159	17159	Бумбат 56	24.44	Заамар	Бумбат	2075652	2003.11.11
14	MV-017156	17156	Бумбат-188	46.13	Заамар	Бумбат	2075652	2004.07.06
15	MV-017157	17157	Бумбат-197	39.67	Заамар	Бумбат	2075652	2004.07.06
16	MV-011882	11882	Ар тамсаг-1-3-1	145.53	Заамар	Хосхас	2100231	2004.12.08
17	MV-011881	11881	Ар тамсаг-1-1-1	144.53	Бүрэгхангай, Заамар	Хосхас	2100231	2004.12.08
18	MV-009515	9515	Зүүн цагаан хошуу-1	210.84	Баянжаргалан	Анхай-Интернэшил	2863847	2005.03.30
19	MV-009516	9516	Гэдгэр хангай	91.16	Баянжаргалан	Анхай-Интернэшил	2863847	2005.03.30
20	MV-016816	16816	Хужиртын гол	53.47	Бүрэн	Нарлагтова жем	5102545	2005.05.23
21	MV-016817	16817	Хужиртын гол-1	96.45	Бүрэн	Нарлагтова жем	5102545	2005.05.23
22	MV-010871	10871	Жаргалант	100.62	Жаргалант	Хулдын нүүрс	5009138	2005.11.30
23	MV-012277	12277	Ханан-Өнжүүл	144.31	Баян-Өнжүүл	Миндуотайди	5082986	2006.12.08
24	MV-014987	14987	Жавхлант	1,423.81	Жаргалант	Хулдын нүүрс	5009138	2009.07.08
25	MV-015244	15244	Хадат	178.31	Баянхангай, Угтаалцайдам	Мөнх аргал уул	5328586	2009.11.06
26	MV-016722	16722	Төхөм	552.42	Бүрэн	Хулд химикалс	5415853	2010.10.16
27	MV-016682	16682	Төхөм	216.85	Бүрэн	Төхөмдавс	5087414	2010.10.16
28	MV-016976	16976	Хуурай нуга	215.18	Жаргалант	Мөнхговийн эрдэнэ	5321182	2011.02.08